

## Эрүүл мэндийн газрын долоо хоногын мэдээ

### Нэг. Зарим статистик үзүүлэлт

Нийт төрөлт - 45  
Амьд төрөлт - 45  
Амьгүй төрөлт - 0  
Дутуу төрөлт - 0  
Нялхсын эндэгдэл - 1  
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл - 0  
Эхийн ноцтой хүндрэл - 0  
Төрөлхийн гажиг - 2  
Гэрийн төрөлт - 0

### НЭГ. АМБУЛАТОРИД СУУРИЛСАН ТАНДАЛТ

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 13 дугаар долоо хоногт нийт 4415 хүн үйлчлүүлсний 217(4.9%) нь ТТӨ -тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 1%-иар буурсан үзүүлэлтэй байна.

### ХОЁР.ЭМНЭЛЭГТ СУУРИЛСАН ТАНДАЛТ

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (285)-ийн дотор буюу 21.7 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 1.2%-иар нэмэгдсэн үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

### ГУРАВ. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГА

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 315 дуудлагын 94(29.8%)-ийг ӨГ -ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 1 %-иар өссөн үзүүлэлтэй байна.

#### **Өнгөрсөн долоо хоногт өгсөн үүрэг даалгавар**

Хотгор багт гарсан хоолны хордлогын сэжигтэй тохиолдолд бүртгэгдсэн мөн хавьтал болсон 18 хүнээс томуугийн вирус тодорхойлох хамрын арчдасын шинжилгээг авч ХӨСҮТ-д шинжлүүлэхэд 18 хүний 88,8 % буюу 16 хүнээс томуугийн А хүрээний вирусийн H3N2 хэв шинжийн вирус илэрсэн ба сөрөг хариу гарсан 2 тохиолдолд тандалт хийхэд бусад хүүхдүүдтэй адилхан шинж тэмдэгтэй эмнэлэгт эмчлүүлж байсан. Одоогийн байдлаар Хотгор багийн эрүүл мэндийн төвд эмчлүүлж байгаа хүүхэд байхгүй гэртээ эмчийн хяналтанд байгаа ба Хотгор багийн эмч, сувилагч нийгмийн ажилтан нар өдөр болгон голомт гарсан хүүхдийн цэцэрлэгт хүүхдийн ирцийн тандалт судалгаа хийж, хүүхдүүдэд эмчийн үзлэг хийж мөн тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Анхаарал татсан хүүхэд одоогийн байдлаар байхгүй.

## Үйл ажиллагаа

1. Өлгий сумын 5 дугаар бүрэн дунд сургуулийн хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг, халдвар өвчнөөс сэргийлэх талаар сургалт, сурталчилгаа хийгдлээ. Эрүүл мэндийн газраас гаргасан 2019 оны халдвартөвчний эрсдлээс сэргийлэх, мэдээлэл сургалт, сурталчилгаа хийх удирдамжийн дагуу Өрл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн А.Нургүл, Шипагер өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч Н. Амангүл, Х. Ахбота, Т. Алтыннур, Нийгмийн эрүүл мэндийн ажилтан Б.Лида, сургуулийн эмч М.Алмагүл нартай хамтран Өлгий сумын 5 дугаар бүрэн дунд сургуулийн 10-12 дугаар ангийн үүхдүүдийг 120 х А гепатит өвчнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, “Хоолны хордлого”, “Гэдэсний халдвартөвчнөөс урьдчилан сэргийлэх”, “А гепатит буюу шар өвчнөөс сэргийлэх”, “Угаарын хийн хордлогоос сэргийлэх”, “Гарын эрүүл ахуй”, “Амьсгалын замын халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр мэдээлэл өгч ажиллаа.
2. 2019 оны 04 дүгээр сарын 4 -ний өдөр Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төв нь аймгийн Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн диспансертай хамтарч Раушан өрхийн эрүүл мэндийн төвд сүрьеэгийн тусламж үйлчилгээний чиглэлээр хэрэгжиж буй эрхүйн актын хэрэгжилт, Засгийн газрын 11-р тогтоолоор батлагдсан “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.
3. Онцгой байдлын газрын албан хаагчдад эрт үүргийн ач холбогдол, давсны хэрэглээний талаар сургалт явуулж, биеийн найралгын аппаратанд орхон б хүмүүст зөвлөгөө өгч ажилласан.
4. ШШГТ-ын албан хаагчдад эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдол, амилуулах суурь тусламжийн чиглэлээр сургалт хийж, 21 хүнийг хамруулсан.
5. Эрүүл мэндийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/119 тоот тушаалаар Баян-Өлгий аймагт вакцин хадгалах өсөн ханатай 2 хөргөгч хуваарилагдаж ирснийг өргөгч нь эвдэрсэн Булган сумын эрүүл мэндийн төв болон Мейрим өрхийн эрүүл мэндийн төвүүдэд гардуулан өгсөн.
6. “Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин”, “Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин” гэсэн хоёр өрлийн вакциныг 2019 оны 04 дүгээр сарын 01 -ний өдрөөс шинээр нэвтрүүлж, 2, 4, 5, 9 сартай хүүхдүүдийг дархлаажуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Үүнтэй холбогдуулан 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдөр аймгийн Эрүүл мэндийн газраас “Пневмококкийн эсрэг вакцин, халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинуудыг дархлаажуулалтад нэвтрүүлэх сургалт” -ыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмч, сувилагч, дархлаажуулалтын ажилтнуудыг чадваржуулах, вакцинтай холбоотой мэдээллээр хангах зорилгоор зохион байгуулсан ба сургалтад 3 сум дундын эмнэлэг, 11 сум, тосгон өрхийн эрүүл мэндийн төвүүд зэрэг анхан шатны 18 эрүүл мэндийн байгууллагуудын 72 эмч, сувилагч, дархлаажуулалтын ажилтан, аймгийн нэгдсэн эмнэлгийн 2 их эмч, Эрүүл мэндийн газрын 4 мэргэжилтэн, нийт 78 эмч мэргэжилтэн оролцлоо.

7. Баян-Өлгий аймгийн Хоодйлдвэрлэгчдийн Галайхан холбооноос зохион байгуулж буй зөвлөгөөн, сургалт семинарт оролцож, 50 хүний даралт үзэж, биеийн жингийн индексийг тодорхойлсон.
8. Мейрим өрхийн эмнэлэгт гэрийн идэвхтэй эргэлтийг сайжруулах сургалт зохион байгуулсан.
9. Ховд аймагт нярайн тасагийнүйл ажиллагаатай сайн туршлага солилцоход ЭМГ, НЭ-ийн мэргэжилтэнгүүд оролцсон.